

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН НАМЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ЧУУЛГАНЫ ТОГТООЛ

2004 оны 07-сарын
16-өдөр

Дугаар. 4/
103

Улаанбаатар хот


УИХ-ын сонгуульд оролцох тухай

МҮЭНН-ын Үндэсний зөвлөлийн 2004 оны 02-р сарын 12-ны өдрийн чуулганы хуралдааны протоколийг үндэслэн Тогтоох нь:

1. УИХ-ын 2004 оны сонгуульд МҮЭННам бие дааж оролцох нь зүйтэй гэж үзсүгэй.
2. МҮЭНН-ын УИХ-д нэр дэвшигчдийг бүртгэж, сонгуулийн комисс хороодыг байгуулан ажиллуулахыг Ерөнхий Зөвлөл /Н.Цэдэнбалжир/-ийн дарга, Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.
3. МҮЭННам УИХ-д оролцох тухай асуудлыг боловсруулж Монгол улсын Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Хоролдамбал үүрэг болгосугай.

МҮЭНН-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН

ДАРГА

 Н.Ням-Осор

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

 Л.Сүхбаатар

МОНГОЛ ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН НАМЫН (МҮЭНН) ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

МҮЭНН 1994 оны тавдугаар сарын 4-нд байгуулагдаж мөн оны 8-р сарын 19-нд Монгол Улсын Дээд Шүүхэд бүртгүүлж, Монгол улсын нутаг дэвсгэр дээр улс төрийн үйл ажиллагаа явуулах хууль ёсны эрхтэй болсон юм.

МҮЭНН-ын анхдугаар их хурлаас их хурлын чөлөөт цагт намын эрхийг барих улирлах дээд байгууллага болох Үндэсний зөвлөлийг байгуулж үндэсний зөвлөлийн дарга бөгөөд намын даргаар Намсрайн Ням-Осорыг сонгон баталсан билээ.

МҮЭНН 1996 оны УИХ-ын сонгуульд 34 хүний нэр дэвшүүлж иийт сонгогчдын 6 хувийн санал авч, монголын улс төрийн хоёр том хүчний дараа орж шинжлэх ухааны академиас гаргасан судалгаагаар хамгийн сайн мөрийн хөтөлбөртэй нам гэсэн үнэлгээ авсан юм.

Тус нам 2004 оны УИХ-ын сонгуульд оролцох гэж байгаа нь УИХ-ын гуравдахь удаагийн сонгуульд оролцож байгаа хэрэг юм.

МҮЭНН-ын Үндэсний зөвлөлийн чуулган 2002 оны 1-р сард хуралдаж намын нэрийг хуучнаар нь буюу Монголын үндэсний эв нэгдлийн нам хэмээн нэрлэхээр болсон юм. Тус намын Үндэсний зөвлөлийн ээлжит чуулган 2004 оны 1-р сард хуралдаж Намын дүрэм, үзэл баримтлалд нэмэлт өөрчлөлт оруулж, намын тэргүүнээр Н.Цэдэнбалжир, дэд тэргүүнээр Б.Баттогтох, Б.Бат-Ерөөлт, Намын ерөнхий нарийн бичгийн даргаар Д.Хоролдамба, нарийн бичгийн даргаар П.Чинбат, Д.Одгэрэл нарыг сонгон баталсан болно. Тус чуулганаас намын ерөнхий зөвлөлийг Б.Ариунгэрэл, Д.Батгөмөр, Б.Батбаяр, Д.Мөнхсайхан, Б.Болортогос, Ч.Нэргүй, С.Жамбалсүрэн, Ч.Батхишиг, Р.Идэрхүү, Ч.Ганзориг, Б.Дашдондог, Г.Наранбаатар, М.Даваадорж, Д.Нямдорж, Ч.Зоригт, Р.Булгамаа, С.Баттулга, З.Арсланбаатар, Ц.Эрдэнэбат, Д.Эрдэнэбат, Д.Гэрэл-Эрдэнэ, П.Энхтуяа, Г.Туяа, И.Шинэ, Д.Чулуунбилэг, Б.Энх-Өлзий, Г.Өлзийбаяр, Э.Эрдэнэчулуун, А.Зая, З.Гансүх, Б.Алтангэрэл нарын 50 тэргүүлэгчидтэй, ЕЗ-ийн гишүүдийг 500 хүний бүрэлдэхүүнтэй байхаар тогтоож, тус намаас 2004 оны УИХ-ын сонгуульд баримтлах мөрийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Ийнхүү МҮЭНН “Шинэ үеийг сонгож байна” гэсэн уриан дор намын дүрэм, үзэл баримтлал, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсронгуй болгон баталж, намын удирдлагуудаа шинэ залуу боловсон хүчнээр бэхжүүллээ.

Намын удирдлагуудын 80 хувь нь 35 хүртлэх насны залуучууд болсон нь МҮЭНН бусад улс төрийн хүчнээс өмнө намаа залуу боловсон хүчнээр бэхжүүлж Монголын ирээдүйг цогцлон байгуулах залуучуудын нам болж төлөвших эхний алхмаа энэ удаагийн УИХ-ын сонгуулиас эхэлж байна. Манай нам одоогийн байдлаар 18000 гаруй гишүүнтэй. МУ-ын 16 аймаг, 126 сум, дүүрэгт анхан шатны байгууллага, нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Намын гол үзэл баримтлал нь монголын төрт ёсны уламжлал, түүх соёлоо сэргээх, үндэсний түүх, гүн ухааны өвийг шинэчлэн хөгжүүлэх зорилт юм. Энэ

үзэл санаандаа үнэнч байгаа бөгөөд эх орон, өв соёлдоо үнэнч хүмүүсээр эгнээгээ байнга өргөжүүлсээр байгаа болно.

МҮЭНН-ын эрх барих байгууллага болох Үндэсний Зөвлөлийн даргаар ИЗИС-ийн ректор доктор.профессор Н.Ням-Осор, тэргүүлэгчээр Дүүхээ ХХК-ийн ерөнхий захирал П.Балдорж, Парадокс ХХК-ийн ерөнхий захирал С.Эрдэнэболд, Бэрс ДС-ийн захирал академич Ч.Гомбосүрэн, НСИА-ийн ерөнхий нарийн бичгийн дарга академич Б.Бат-Очир, зохиолч, сэтгүүлч Н.Нагаанбуу, түүх судлаач Т.Мандир, Саран ээж нийгэмлэгийн ерөнхий менежер Т.Бат-Очир, Цагаан шонхор ХХК-ийн менежер Г.Пүрэвтогтох, ҮЗ-ийн нарийн бичгийн даргаар ИЗИС-ийн ректорын ажлын албаны дарга Л.Сүхбаатар нар ажиллаж байна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН НАМЫН ДҮРЭМ

Нэг. Намын дээд байгууллага

Монголын Үндэсний Эв Нэгдлийн Намын дээд байгууллага нь Намын их хурал мөн. Намын их хурлаас үндэсний зөвлөлийн дарга болоод үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг батална. Түүний чөлөөт цагт намын их хурлаас сонгогдсон намын үндэсний зөвлөлийн чуулган намын дээд эрхийг барина. Үндэсний зөвлөлийн чуулган хагас жил тутам чуулж, намын амьдралын тулгамдсан асуудлыг авч хэлэлцэнэ.

Намын Үндэсний зөвлөл намын үзэл, дүрмийг боловсруулж батлах, биелэлтэд нь хяналт тавих үүрэг бүхий намын удирдах дээд байгууллага мөн. Намын үндэсний зөвлөл нь 100 хүнээс бүрдэнэ. Үндэсний зөвлөлийн нэг тэргүүлэгч гишүүн 10 хүний төлөөлөлтэй байна.

Үндэсний зөвлөлийг намын үндэсний зөвлөлийн дарга тэргүүлж, намын даргын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Монголын Үндэсний Эв Нэгдлийн Намын үндэсний зөвлөлийн чуулган улс эх орны болон намын өмнө тулгамдсан зарим асуудлыг авч хэлэлцэж, шийдвэр гаргах бөгөөд намын ерөнхий зөвлөлийн тэргүүлэгчид, намын ерөнхий зөвлөлийн тэргүүн, дэд тэргүүн, ерөнхий нарийн бичгийн даргыг сонгон батална.

Намын ерөнхий зөвлөлийн тэргүүн болоод ерөнхий нарийн бичгийн дарга нар намын өдөр тутмын ажлыг удирлан зохион байгуулна.

Намын ерөнхий зөвлөл улиралд 1, тэргүүлэгчид сард 1 удаа хуралдана.

Хоёр. Намын удирдах байгууллага

Монголын Эв Нэгдлийн Намын ерөнхий зөвлөл намын өдөр тутмын ажлыг зохион байгуулна. МҮЭН Намын ерөнхий зөвлөлийн тэргүүн, намын тэргүүний бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Намын ерөнхий зөвлөлийн тэргүүлэгчид 50 гишүүнтэй байх бөгөөд ерөнхий зөвлөлийн тэргүүлэгч бүр 9 гишүүний төлөөлөлтэй байна. Ерөнхий зөвлөлийн тэргүүлэгчид Намын ерөнхий зөвлөлийн гишүүн тус бүр 9 гишүүнийхээ бүртгэлийг үндэсний зөвлөлд танилцуулж, бүрэн эрхийн мандатаа авна.

Намын ерөнхий зөвлөлийн гишүүн тус бүр 9 гишүүний төлөөлөлтэй байх бөгөөд эдгээр гишүүдээс бүрдсэн гүйцэтгэх зөвлөл байгуулагдан ажиллана.

Намын бүх шатны идэвхтэн сонгуультанууд намын үндэсний зөвлөл, ерөнхий зөвлөл, гүйцэтгэх зөвлөлийн аль нэгний гишүүн байна.

Намын ерөнхий зөвлөлөөс аймаг, хот дүүрэгт бүрэн эрхт, сум хороо багт итгэмжлэгдсэн төлөөлөгчдийг томилно. Бүрэн эрх болон итгэмжлэгдсэн

төлөөлөгчид нь намын орон нутаг, анхан шатны байгууллагыг байгуулж, удирдлага, туслалцаагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүрэг хүлээнэ.

Намын бүрэн эрхт болон итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд тус намын үзлийг дэмждэг бусад намын гишүүд, нам бусчууд Үндэсний эв нэгдлийн хөдөлгөөний гишүүд хамрагдан ажиллаж болно.

Гурав. Аймаг, хот, дүүргийн намын байгууллага

Намын бүрэн эрхт төлөөлөгч нь 10 гишүүний төлөөлөлтэй байж, үндэсний зөвлөлөөс бүрэн эрхийн мандатаа авна. Аймаг, хот, дүүргийн намын хороо нь 10 гишүүнтэй байх бөгөөд хорооны гишүүн нь 10 гишүүний төлөөлөлтэй байна. Хорооны гишүүд 10 гишүүнийхээ бүртгэлийг бүрэн эрхт төлөөлөгчид танилцуулж, бүрэн эрхийн мандатаа авна. Намын хорооны бүгд хурал, аймаг, хот дүүргийн болон намын хорооны өмнө тулгамдсан асуудлыг авч хэлэлцэж, шийдвэр гаргах бөгөөд намын хорооны тэргүүлэгчид, хорооны даргыг сонгон батална. Намын хорооны дарга тэргүүлэгчдийг удирдаж, намын өдөр тутмын ажлыг гардан зохион байгуулна.

Намын хорооны бүгд хурал улиралд 1, тэргүүлэгчдийн хурал сард 1 удаа хуралдана.

Дөрөв. Сум, хороо, баг, хэсгийн намын байгууллага

Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь 10 гишүүний төлөөлөлтэй байж ерөнхий зөвлөлөөс итгэмжлэхээ авна. Сум, хороо, баг, хэсгийн намын хороо нь 10-иос доошгүй гишүүнтэй байх бөгөөд хорооны гишүүн нь 10 гишүүний төлөөлөлтэй байна. Хорооны гишүүд 10 гишүүнийхээ бүртгэлийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид танилцуулж, бүрэн эрхийн мандатаа авна. Намын хорооны хурал, сум, хороо, баг хэсгийн болон намын хорооны өмнө тулгамдсан асуудлыг авч хэлэлцэж, шийдвэр гаргах ба хорооны дарга, тэргүүлэгчдийг сонгож багална.

Намын хорооны дарга, тэргүүлэгчдийг удирдаж, намын хорооны өдөр тутмын ажлыг гардан зохион байгуулна. Намын хорооны хурал улиралд 1, тэргүүлэгчдийн хурал сард 1 удаа хуралдана.

Тав. Намын гишүүд, дэмжигчид

Монголын Үндэсний Эв Нэгдлийн Нам үндэсний зөвлөл, Ерөний зөвлөл, гүйцэтгэх зөвлөл, аймаг, хот, дүүрэг, сум, хороо, баг, хэсгийн бүрэн эрхт болон итгэмжлэгдсэн төлөөлөгч, намын хорооны дарга, тэргүүлэгчид нь энгэрийн тэмдэг, үнэмлэхтэй байна.

Монголын Үндэсний Эв Нэгдлийн Намын гишүүдийн татвар жилд 1000 төгрөг байх бөгөөд үндэсний зөвлөлийн гишүүд, ерөнхий зөвлөлийн гишүүд нь улиралд 1000 төгрөгийн татвар төлнө.

Монголын Үндэсний Эв Нэгдлийн Намын Үндэсний зөвлөл, Ерөнхий зөвлөл, гүйцэтгэх зөвлөл, аймаг, хот, дүүрэг, сум, хорооны намын хороод нь бичгийн хэвлэмэл хуудас, тамга тэмдэг, туг, дарцаг, санхүүгийн харилцах данстай байна.

Намын санхүүгийн үйл ажиллагаанд намын үндэсний зөвлөл, ерөнхий зөвлөл, бүрэн эрхт болон итгэмжлэгдсэн төлөөлөгчид байнгын хяналт тавьж илэрсэн зөрчлийг шуурхай арилгана.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН

НАМЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

УЛС ТӨРИЙН НАМУУЛДЫН ТУХАЙ ХУУЛЬ

4 дүгээр зүйл. Намын үйл ажиллагааны үндсэн зарчим

Нам үйл ажиллагаандаа жор дурдсан үндсэн зарчмыг баримтална.

а) Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн сахин биелүүлэх;

б) эх орон, ард түмний нийтлэг эрх ашгийг нийлүүлэн үйл ажиллагаа идэвхт явуулах;

в) бусад намын цэр төрийг хүндэтгэх, логосод хэрэглэж хөндлөнгөөс үл оролцох, тэдгээрт өөрийн үзэл бодлыг тулган шаардахгүй байх;

г) өөрийн ажрийн хөтөлбөрөө нарийн чанд сахин мөрдөх;

д) хүмүүшлэг, ардчилсан энэрэнгүй ёсыг эрхэмлэн дээдлэх;

е) Монгол улсаас бусад оронтой тогтоосон найрамдал, хамтын ажиллагааг эрхэмлэн хүндэтгэх

Монгол Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 р сарын 22-ны өдрийн 02 р тогтоолоор

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН

намыг улсын бүртгэлд бүртгэв.



Р. БАЛГАЖИР
Б. ЦОГЦИМ
Д. ТУНГАЛАМ

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЭВ НЭГДЛИЙН
НАМЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН
ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭС**

(мал аж ахуйгаа хөгжүүлж, малчнаа дээдлэе)

МҮЭНН хэрвээ эрх баригч нам болсон тохиолдолд:

1. Монгол улсыг ерөнхийлөгчийн засаглалтай, хоёр танхимтай парламенттай болгоно.

2. Байнгын бус үйл ажиллагаатай, бүх сумдын төлөөлөлтэй Ардын их хурал байгуулж, Төрийн бүх эрх ард түмний гарт байна гэсэн Монгол улсын Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлнэ.

3. Монгол Улсыг 5 мужийн зохион байгуулалтад шилжүүлж, удирдлагын шат дамжлагыг багасгана.

4. Монгол бичгийг крилл бичгийн нэгэн адил төрийн албан ёсны бичиг болгож, монгол улсын ард иргэдийг хос бичигтэн болгоно.

5. “Их засаг” болон бусад эртний хуулиудын шилдэг уламжлалыг Монгол улсын хууль тогтоомжуудад тусган хэрэгжүүлж, Монгол Улсын үндсэн хууль боловч бусад хууль тогтоомжийн уламжлал, шинэчлэлийг хангаж, үйлчлэх чадамжийг дээшлүүлнэ.

6. Хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг төрөөс хамгаална гэсэн Үндсэн хуулийн заалтыг биелүүлээгүй тохиолдолд учирсан хохирлыг төр засгийн зүгээс төлдөг болгоно.

7. Мал аж ахуйн түүхий эдийн захуудыг сумдын төвүүдэд байгуулах замаар худалдаа үйлчилгээг малчдад ойртуулж, малчдын зардал, чирэгдлийг бууруулж, тэдний бэлэн мөнгөний гачааллыг арилгана.

8. Малчин айл өрх бүрд байгаль цаг агаарын хүндрэлтэй нөхцлийн тэтгэмж болгож улиралд 100.000 төгрөг олгоно.

9. Их дээд сургууль, коллежийн оюутнуудад сар бүр 20.000 төгрөгийн тэтгэлэг олгоно.

10. Хөдөөгийн МАА-н багууд, хотын хороо, хэсгийн нийгэм соёлын арга хэмжээний зардалд сар бүр 100.000 төгрөг олгоно.

11. Сумын дунд сургуулийн математик, монгол хэлний багш, бага ангийн багш нарт сар бүр 50.000 төгрөгийн хөдөөгийн нэмэгдэл олгоно.

12. Сумын хүний их эмчийн салбарын эрхлэгчид сард 100.000 төгрөгийн хөдөөгийн нэмэгдэл олгоно.

13. Олон хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж болгож 4 хүүхэдтэй эхэд сард 40.000 төгрөг, 5 хүүхэдтэй эхэд сард 50.000 төгрөг, 6 хүүхэдтэй бол 60.000 төгрөг гэх мэтээр тус бүр 10.000 төгрөгөөр өсгөн нэмэгдүүлэх журмаар тэтгэмж олгоно.

14. Хөг суурин газраас хөлөө рүү нүүж малчин болж буй айл орхийн нүүдэл суудлын зарлалд зориулж нэг удаа 200.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.

15. Нийгмийн эмзэг хэсэгт зориулсан нийтийн хороолол байгуулж, тэднийг орон байртай болгох асуудлыг шийдвэрлэнэ.

16. Малчдын өвөлжөөний орон сууцны тусгай хөтөлбөр боловсруулж, тэднийг өвөлжөөндөө тохилог дулаан сууцтай болгох асуудлыг шийдвэрлэнэ.

17. Сүү, сүүн бүтээгдэхүүний дэлхийн стандартад нийцсэн үйлдвэрүүд байгуулж, бүтээгдэхүүнийг галаад дотоодод борлуулж, малчин өрхийн дундаж орлогыг 3 дахин нэмэгдүүлнэ.

18. Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхдээ улсын төсвийн үргүй зардлыг багасгах, аппаратыг бичиг ажлыг санхүүжүүлэх, тансаг хэрэглээг багасгах, галаад дотоодын зээл тусламжийг хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд чиглүүлэх, улс нийгмийн баялгийг ард түмний хүртээл болгоход гол анхаарлаа хандуулна.

МҮЭНН-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

МӨНХ ТЭНГЭРИЙН ХҮЧИН ДОР НЭГДЭГТҮН!

Монголын Үндэсний Эв Нэгдлийн Намын
/МҮЭНН/ мөнх тэнгэрийн хүчний үзэл санааны үндэс

I. Энх амгалангийн ертөнцийг бий болгоё.

Хүн төрөлхтөн бид туулсан замаа эргэн харж, өөрт буй нөөц (хүн төрөлхтөний соёлын их өв сан, бурхад болон мэргэдийн сургаал номлол, зөн совин, шинжлэх ухааны мэдлэгийн төвшин гэх мэт) боломжоо ашиглан, бүхнийг учир шалтгааны гүн гүнзгий хэлхээ холбоонд авч үзэж, дүн шинжилгээ хийх цаг үе нэгэнт тулжээ.

... Оюун ухаант хүн эх дэлхий дээр анх нүцгэн шалдан мэндэлж, орох орон, оочих аяга ч үгүй, араатан амьтдын довтолгоо болон байгалийн сүр хүчний өмнө дагжин чичирч зогссоноор амьдралын түүхээ эхэлснээс хойш мянга, мянган жилийг ардаа орхиж, цаг хугацаа улиран одохын хирээр хүч чадал нь улам бүр зузаарч, эдүгээ атомын эрчим хүчийг ч гартаа оруулж, машинд хүчирхэг болоод байна.

Шинжлэх ухааны ололт амжилтын нээж өгсөн замаар чухам хаашаа явж буйгаа ч үл анзааран зүтгэсээр, нэг л мэдэхэд төхнологийн дэвшлээр эх дэлхийгээ “зүү орох зайгүй” болтол нь торлон хүлсэн эдүгээ цаг үеийн хүн төрөлхтөний хөгжлийн төвшинг, түүхийн эхэн үетэй харьцуулахад үнэхээр бахархаж, бахадмаар гайхамшигтай амжилт мөн боловч энэ бүх хөгжил дэвшлийн эцсийн үр дагавар нь оюун ухаант хүн төрөлхтөний эсрэг болон хувирсаар байгааг ухаарч;

- Бидний амьдрах язгуур үндэс болсон шим мандлын сүйрэл газар авч, агаар, ус маш ихээр бохирдон муудаж, үй олон гол, ус, нуур цөөрөм ширгэн хатаж, ургамал ногоо, элдэв төрлийн амьтад зүйл зүйлээрээ хорогдон цөөрөх буюу бүр мөсөн мөхөж, цаг агаар, уур амьсгалын хүчтэй хямрал болж, байгалийн элдэв гамшигт үзэгдлүүд нэн элбэгшээд, дэлхий ээж маань халууран бүлээрч байна.

- Мөн бурхнаас манай гаригийн хүн нэг бүрд хайрласан гэрэл гэгээтэй, ариун тэнгэрлиг чанарууд алга болж, харин оронд нь “би үхэхээр чи үх” , “Би л болж байвал бусад нь хамаагүй!” хэмээх хар амиа хичээсэн бусармаг үзэл газар авч, түүнийг дагалдан хүмүүний хамгийн муу муухай чанар туйлдаа хүртэл дэвэрч, цаашид хүлцэн тэвчиж, хүлээн зөвшөөрөхийн аргагүй болсоор байна.

Манай гаригийн хүн нэг бүрийн оюун санаанд заяамал оршиж оюун ухаан, сайхан сэтгэл хоёр харилцан шүтэлцсэн зөв сайн үйлийн мөрөөр явах учиртай

байтал гайхамшигт энэ хоёр мөн чанарын дан ганц арга ухааныг нь шүтэн биширч, сэтгэл гэдэг эрхэм чанарыг гээснээр бие нь бүтэн боловч оюун ухаан нь хагас эрэмдэг зэрэмдэг хүн- араатан, хүн-адгуус энэхүү “соёлт өртөнц” гэгчид өсөн бойжиж байна.

Гэтэл төхник технологийн дэвшил, цахим тооцоолуурын түрэн орж ирж байгаа нөлөөгөөр манай гаригийн үйл амьдрал өдрөөс өдөрт улам бүр бие биенээсээ хамааралтай болсоор байгаа бөгөөд энэхүү цаг үед аль нэг улсын ирээдүй гэж огтхон ч байхгүй болж, харин хүн төрөлхтөнд хамтын нэг л хувь заяа, хамтын нэг л ирээдүй бодитойгоор буй болж, бид нэгэн их гэр бүл болж, төлөвшиж байна.

Шим мандлын амин орчин үлэмж ихээр доройтон муудаж байгаа нөхцөл байдал болон хүн төрөлхтөний үйл ажиллагааны өргөн цар хүрээ бид бүхнийг нэгтгэн зангидсаар байна.

Өнөөдөр дэлхийн улс орны удирдагчид өөр өөрийн орны эрх ашиг гэж ярьж, бичиж байгаа боловч харилцан хамааралтай дэлхий ертөнцийн бодит амьдрал дээр, энэ нь улам бүр суларч, харилцан шүтэлцээтэй хамтын, нэг л эрх ашиг ялгаран тодорсоор байна.

Иймээс “шуудайд хийсэн үхрийн эвэр” шиг сөргөлдөн тэмцэлдсэн хүн төрөлхтөний санаа сэтгэлийг нэгтгэн зангидаж чадах үзэл санаа, онол бодлогыг буй болгох нь тэргүүн зэргийн тулгамдсан зорилт болж байна.

Үүнийг зөвхөн хамгийг хайрлан энэрч, халамжлан анхаарч, ойлгон хүндэтгэж, халуун дулаан сэтгэлээр л хийх ёстойгоос бус, өөр ямар ч аргаар бүтээн буй болгож чадахгүй болой.

Өнөөгийн энэхүү хүйтэн цэвдэг, бурангуй цаг үед чин үнэнч ариун сэтгэл, хайр халамж асар ихээр дутагдаж байна. Харин хүн төрөлхтөнийг халуун хайр, зөв оюун санаагаараа ивээн тэтгэж, халамжилж чадах хүч энэ дэлхий дээр байна уу?

Энэ бол мөнх тэнгэрийн хүчний газар дээрх төлөөлөл болсон бодит оюунлиг хүчин хөх Монголчуудын тэнгэрлэг ухаан болой.

Эзэн Чингисийн их монгол улсын төрийн тамган дээр “Мөнх тэнгэрийн хүчин дор” гэсэн эрхэмсэг үгс сийлээстэй байдаг.

Монголчууд нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдардаг учраас нар, сар, од эрхис, агаар тэнгэрийн байдлыг үргэлж ажиглан судалж, түүний нөлөөллийг ажил

амьдралдаа гойд чадварлаг хэрэглэж чаддаг эрдэмтэн судлаачид, мэргэн зурхайчид байжээ.

Мөнх тэнгэрийн хүч гэдэг нь мөнх тэнгэрийн төөрөг заяа, жам ёс гэсэн үг болой.

Нар сар, од эрхэс, орчлон хорвоогийн юмс үзэгдэл цөм мөнхийн хөдөлгөөнд оршиж, бие биенээсээ харилцан хамааралтай хувирч өөрчлөгдөж, байдаг жамтай.

Хүн хэдийгээр мөнх бусыг үзүүлдэг ч түүний оюун санаа үүрд мөнх оршдог. Их эзэн богд Чингис хааны амин сүнс буюу оюун санаа нь мөнх хөх тэнгэрт мөнхөд оршиж, дэлхий өртөнцийн тэр дундаа монголчуудын ажил амьдралыг байнга тольдож харж, сайныг нь ивээн, саарыг нь мохоож байдаг ажгуу.

Тэгэхээр мөнх тэнгэрийн хүч гэдэг бол хязгааргүй огторгуйд хуримтлагдсан асар их эрчим хүч бөгөөд энэ нь нарны аймгийн бүхий л од эрхис, гариг дэлхий, хүн зон, амьд байгалийн амьдрал ахуйг зохицуулагч мөнхийн хөдөлгүүр болой.

Тэнгэрийн буюу байгалийн энэхүү хүч нөлөөллөөс ангид ямар ч амьдрал хорвоод үгүй бөгөөд энэхүү их хүчийг зөв ажиглаж хэрэглэж чадсан улс орон, хүн ард хөгжин мандаж, эсрэгцэн тэрсэлдсэн, байгаль орчин, улс ард мөхөж доройтдог нь жамтай билээ.

МҮЭНН мөнх тэнгэрийн хүчний энэхүү шидэт хүч чадлыг улс орон, хүн ардынхаа амьдрал ахуйг өөд татан хөгжүүлэх үйл ажиллагааныхаа гол чиглэл болгон дэвшүүлж байна.

II. Монголчуудын эрин үеийн түүхэн үүрэг хариуцлага

Хүний бодол санаа, үг яриа бичил долгион /эрчим хүч/ цацруулдаг нь нэгэнт тодорхой бөгөөд хүн төрөлхтөний өөрсдийнх нь буй болгосон атгаг санаа, хорон сэтгэл, муу үйлийн хар эрчим хүч эх дэлхийг маань битүү бүрхжээ.

Сүүлийн жилүүдэд Монголчууд эхийн тухай дуу дуулах явдал эрс нэмэгдэж байгаа нь энэхүү “соёлт өртөнц” гэгч нь асар их нүгэл хилэнцэт замаар замнаж, харанхуй мунхгаасаа болж, хүн төрөлхтөнийг ч, байгаль дэлхийгээ ч сүйтгэн доройтуулж, зүрх сэтгэл, ёс суртахуунаа алдаж гээсээр, тэр бузар булай, зэрлэг догшин хүйтэн цэвдэг бохир “сарвуу” нь халуун дулаан сэтгэлтэй, хар буруу санаагүй Монголчуудын маань гэгээн бие сэтгэлийг зүсэн сийчиж, муу муухайн ямар их аймшигт аюул нөмрөн орж ирж байгааг мэдрэн шаналсан ард түмний маань Ижий Бурхандаа хандан аврал эрсэн зүрх сэтгэлийнх нь их дуудлага тэр болой.

Энэ нь Монголчууд бол сэтгэл оюуны эрхэм дээд язгууртнууд мөн болох олон баримтын зөвхөн нэгэн нотолгоо юм. Хүн бүхэн ижийгээс төрсөн мөртлөө Монголчуудаас өөр ямар ард түмэн ингэтлээ ижийнхээ ач тусыг бахархан хүндэтгэж дуулдаг билээ?! Үнэндээ манай “соёлт ертөнц гэгч” ижийн тухай дуу дуулах нь бүү хэл, ижийн тухай дуу дуулахаас ичдэг болтлоо, ижийгээ мартталаа “хөгжлийн” тухай сэрүүн зүүдэлнэм бус уу?

Монголчууд бид шинэ эринийг хамгийг хайрлан энэрэх, халуун дулаан сэтгэлээсээ угтан авч, явал эх сайхан дэлхийдээ хүн төрөлхтөн бид эв найртай, энх амгалан аж төрж чадах бол?! хэмээн зүрх сэтгэлээ шаналган байж, сэтгэл оюунаа дайчлан олон сайхан ном зохиол бүтээн, эх сайхан дэлхийн төлөө, энэ сайхан хүн төрөлхтөний төлөө чин халуун сэтгэлээсээ санаа тавьсаар байна.

Монголчууд мөнх тэнгэрийн буюу дээд оюун санааны газар дээрх элч төлөөлөгчид гарцаагүй мөн бөгөөд үүнийг хэн ч няцааж үл чадна. Тэртээ 800 жилийн өмнө дов довоо сахин суусан хэсэг бусаг ард түмнүүдийг хооронд нь уулзуулан золгуулж, харилцан шүтэлцэж амьдрах зам мөрийг нь зааж өгч, хөгжин дэвших гүүр нь болж байсан бол Бумбын эрин эхэлж буй XXI зууны эхэн үед хүмүүний сэтгэлийн дотоод ертөнц, оюун санааны боловсролын төлөө санаа тавих боллоо.

Монголчууд оршин байгаа нь хүн төрөлхтөний төлөө эцгийн хайр, эхийн сэтгэлээр халамж анхаарал, тавих цорын ганц зорилготой ба энэ нь мөнх тэнгэрээс бидний монголчуудад оноосон зайлахын аргагүй хувь тавилан, зайлшгүй гүйцэтгэх ёстой түүхэн үүрэг хариуцлага болохыг улам бүр ухааруулж байна.

III. Хүн төрөлхтний дагаж мөрдөх тулгуур үзэл

Ухаант хүмүүн бид хэрхэн аж төрж буйгаа, хэрхэн аж төрөх ёстойгоо зөвөөр ойлгож, зөвөөр танин мэдэхийн тулд байгаль дэлхий болоод орчлон ертөнцийн зүй тогтол, мөн чанар, хүн гэдэг маань чухамдаа “юу” болох, “хэн” болохыгоо тодорхойлон гаргах нь бидний онолын сэтгэлгээний тэргүүн зэргийн зорилт бөгөөд хүн төрөлхтөн бид өөрсдийгөө “хэн” болох, “юу” болохыгоо зөв танин мэдэж, зөв тодорхойлохгүйгээр манай гаригийн хувь заяаны ямар ч асуудлыг үнэн зөвөөр шийдэх боломжгүй юм. Иймд хүн төрөлхтөний санаа бодлоос үл хамааран бодитойгоор оршин буй орчлон ертөнцийн язгуур ухагдахууныг ийн тодорхойлов.

Сүнсний тухай ухагдахуун

1. Сүнс гэдэг нь өөрийн үйлийн тухай мэдээллийг хадгалан, өнгийг агуулж, өнгөнд хувиран сэтгэл ба оюун хэмээх үндсэн суурь хоёр мөн чанарыг агуулан тээж, уг хоёр мөн чанартаа түшиглэн, өөрөө өөрийгөө боловсруулан хөгжүүлж, оюун санааны төрөл дэвших дээшлэх учиртай оюунлиг эрчим хүчин бие бөлгөө.

2. Манай гариг дээр оршин амьдарч байгаа амьтай бүхэн сүнсстэй бөгөөд сүнсстэй бүхэнд сэтгэл ба оюуны мөн чанар оршин буй.

Чухамдаа бидний биологи бие маань оюун санааны "тушаал захирамжийг" гүйцэтгэн хэрэгжүүлэгч ажээ. Иймд хүмүүн биеийг олж төрнө гэдэг нь өөрийгөө боловсруулж хөгжүүлэх хосгүй сайхан боломжийг олгож буй сансарын хоромхон зуурын агшин болой.

Сүнс нь "Дээд оюун санаанд" харъяалагддаг учир хүмүүс өнгөн дээрээ бие биенээсээ санаа бодол, үйл ажиллагаагаа нууж чадаж байгаа мэт харагдавч "Дээд оюун санааны" өмнө бүхий л үйлдэл нь дэлгээтэй мэт илхэн байдаг. Сүнс өөрийн биологи биеийг орхин одохдоо эх дэлхий дээр туулж өнгөрүүлсэн бүхий л амьдралаа дээд оюун санааны толинд илхэн хардаг.

Ер нь сүнсний "захирамжийг" биологи биед дамжуулах үүргийг уураг тархи гүйцэтгэдэг бөгөөд уураг тархи нь харьцангуй бие даан сэтгэх чадвартай байдаг ба өөрт агуулагдах сэтгэлгээний элементүүдийг зөв өдөөн сэрээж, зөв ашиглаж чадсанаар өөрийн сүнсийг эзэмдэн залж, гайхамшигт хүрэх нөхцлийг бүрдүүлэн буй болгодог. Сүнсний хувьд уураг тархины үйл ажиллагаа нээлттэй "бичигдэж" байх боловч уураг тархины хувьд сүнсэндээ нэвтрэх үүд хаалга нь "түгжээтэй" байдаг бөгөөд үүний түлхүүр нь гэгээрэл бүхий оюун санааны зөв боловсрол ажгуу.

Орчлон ертөнцийн аливаа бүхэн ижил бус, эсрэг бус хоёр өөр мөн чанарын харилцан шүтэлцсэний үр дүнд оршин тогтнож, "амь ордог" ба хүмүүн ч гэсэн өөрийн үйл амьдралд энэ хоёр мөн чанарыг зөв шүтэлцүүлэн байж, сая зөв аж төрөх учиртай болой. Харин хэрхэн шүтэлцүүлэх арга билгийг хүмүүст бурхнаас заяасан бөгөөд энэ нь оюун санаанд агуулагдан орших оюун ухаан ба сэтгэл хэмээх хоёр мөн чанар даруй мөн билээ.

Сэтгэл хэмээх мөн чанарын дотор сайныг мэдрэн таниад баярлан догдлох мөн чанар, мууг мэдрэн таниж эмзэглэх мөн чанар сүнс бүхэнд заяамал байдлаар оршдог ажгуу.

Биологи бие нь зуурдаар өгүүтгэгдсэн тохиолдолд тухайн сүнсний оюун санааны нь төлөвшил, дэлхий дээр хийж гүйцээгүй ажил хэрэг, материаллаг хэрэглээ, ойр дотны хүмүүс болон бусад янз бүрийн шалтгаанаар дэлхийн амьдралд хэт хоргодох сэтгэл нь тухайн сүнсийг “завсрын ертөнцөд” гацааж, элдэв сүг сүнс, хий үзэгдэл, буг чөтгөр гэж хэлэгдэх үзэгдлүүд буй болох үндсэн нөхцлийг бүрдүүлдэг.

Иймд оюун санаагаа зөв сайхнаар боловсруулан төлөвшүүлэх, биологи биеийг жам бусаар өгүүтгэхгүй байх, жам бусаар өгүүтгэгдэхээс сэргийлэн болгоомжлох нь хүмүүн бидний эрхэм чухал зорилт мөн болой.

Хүмүүний тухай ухагдахуун

1. Тус тусдаа өөр өөрийн үүрэгтэй боловч, харилцан бие биендээ нягт уялдаа шүтэлцээтэй агаар, ус, хөрс шороо, ургамал ногоо болон янз бүрийн амьтдын үйлээс хэлхэгдсэн маш тансаг, үгээр бүрэн төгс илэрхийлэхэд төвөгтэй, бие биенээс нь салгахын аргагүй нэгдмэл цогц амьд систем бүхий, хэм хэмжээ, орон зай, цаг хугацаанд сүлэгдэн орших амин ертөнцийн бүрэлдэхүүн хэсгийн нэг нь хүмүүний биологи бие ажгуу.

2. Харин хүмүүний оюун санааны бие нь эрчим хүчин хэлбэрээр оршин, өөрийн сэтгэл оюунаас үүсэх эрчим хүч, бусад дүрсийн амьтад болон ургамал ногоо зэргээс үүсэх эрчим хүч, мөн эх дэлхийн эрчим хүчний соронзон орон, түүнчлэн од гаригсаас үүсэх эрчим хүч, улмаар төсөөлж болох, төсөөлж үл чадах ил далд ертөнцийн эрчим хүч, эцэст нь бүх ертөнцийн нэгж бүрд нэвчин шингэж оршсон “Дээд оюун санаа” буюу Бурхны цаглашгүй эрчим хүч зэрэг харилцан нөлөөлж, уялдах, сүлэлдэх, шүтэлцэх, нэвтрэлцэх, үл нэвтрэх эрчим хүчнүүдийн эмх замбараатай болон эмх замбараагүй урсгалын зангилаанд хамрагдах ажээ.

3. Ийнхүү хүмүүний бие нь /бусад биологи дүрсүүд ч мөн адил/ биологи бие болон эрчим хүчин бие болох харилцан шүтэн барилдсан хоёр үндсэн биенээс бүрэлдэн тогтдог бөлгөө.

4. Хүмүүн нь биологи биет дүрсийн хувьд бусад амьтад, ургамал ногооныхоо нэгэн адил эх дэлхийн шим мандалд шүтэн амьдрах хувь тавилантай хэдий ч үйл бүтээх боломж чөлөөгөөр хангагдсан бие цогцсын зохистой хэлбэрээрээ давуу талтай.

5. Хүний биологи бие нь түүнийг бүрэлдүүлэгч эцэг, эхийн болон тэдний өмнөх үеийн биологи биеийн болон сэтгэл оюуны зарим нэгэн хэв шинжийг агуулсан байдаг.

6. Хэдий тийм боловч эх дэлхий дээр мэндэлж байгаа хүн нэг бүр дахин давтагдашгүй цорын ганц хувь төрдөг нь үнэхээр юутай ч зүйрлэшгүй гайхамшигтай хэрэг явдал мөн бөгөөд энэ нь хүн нэг бүрийг хосгүй эрдэнэ мэт дээдэлж байгаа Бурхны хишиг билээ.

7. Хүний биологи бие нь эх дэлхий дээрээ бүрэлдэн буй болж, эргээд эх дэлхийн шим мандалд уусан шингэдэг.

8. Харин сэтгэл ба оюуныг агуулан тээгч эрчим хүчин бие болох сүнс нь нэгэнт хэрэгцээгүй болсон бие цогцсынхоо хүлээснээс ангижран салж, оноолт ертөнц рүүгээ харван оддог.

9. Хүмүүний биед хүлэгдэн оршдог ч сэтгэл ба оюун бүхий сүнс хэмээгч нь биологи биеийг удирдан жолоодогч нь даруй мөн билээ.

10. Хүмүүн бидний аливааг ойлгох, танин мэдэх, хүсэл эрмэлзлэл, зан төрх харилцан адилгүй байдаг нь сүнсний өмнөх төрлийн мөн чанраас хамаарч буй хэрэг ажгуу.

11. Иймд оюун ухаант хүмүүн нь бие биенээ ялгаварлан хандахад бус, харин эрдэнэт сайхан хүн болон төрж, ухаант хүн төрөлхтний эгнээнд нэгдэж байгаад нь үргэлж талархаж явах учиртай.

12. Хүн болохын утга учир нь оюун санаагаа хөгжүүлэхэд орших учир тоотой хэдхэн хоног эх дэлхий дээр ирээд буцахын хооронд өөрийн болон бусдын Тэнгэрлэг, оюунлиг мөн чанарыг дээд зэргээр бадраан хөгжөөж, бие биенээ дэмжин тусалж, хамтран ажиллах нь Бурхнаас хүмүүнд оноосон хувь тавилан, үүрэг хариуцлага мөн болой.

Амьдралын тухай ухагдахуун.

1. Сэтгэл ба оюуныг агуулан тээгч эрчим хүчин бие болон сүнсүүдийн аливаа нэгэн зорилгод хүрэх тэмүүлэл бүхий харилцан эрчим хүч солилцох хамтын эерэг ба сөрөг үйл хөдлөл, хөдөлгөөнийг амьдрал гэнэм.

2. Амьдралын агуулга хэлбэр тоо томшгүй байж болох боловч уурагт бие махбодид шилжиж биежсэн биологи биений болон биежээгүй эрчим хүчин биений гэсэн хоёр үндсэн хэлбэрээр оршин тогтнодог.

3. Мөн амьдрал нь орон зайт, хэм хэмжээт, цаг хугацаат орчин нөхцөл болон орон зайгүй, хэм хэмжээгүй, цаг хугацаагүй орчин нөхцөл гэсэн хоёр үндсэн мөн чанараар оршин байдаг.

4. Манай гаригийн хувьд амьдрал нь хэм хэмжээт, орон зайт, цаг хугацаат мөн чанараар оршин тогтнож буй уурагт бие махбодийн амьдрал ажгуу.

5. Амьдрал мандах бадрах болон доройтон мөхөх эсэх нь тухайн оюун ухаант соёл иргэншил "Аз жаргал" хэмээх гайхамшигт ухагдахууныг хэрхэн ойлгосон болон аз жаргалдаа хүрэхийн тулд ямар арга хэрэглэж, хэрхэн аж төрж буйгаас бүрэн шалтгаална.

6. Харилцан нягт уялдаж шүтэлцсэн орчлон ертөнцөд бие биенээ ойлгон хүндэтгэж, хайрлан энэрч, туслан дэмжиж, бие биендээ сайнаар нөлөөлж байж сая эдлэх учиртай хамтын бүтээл бол Аз жаргал юм. Учир шалтгаант уялдаа холбоогоор хэлхэгдсэн хамтын ертөнцөд нэг хүний, хэсэг бүлэг хүний, нэг улс орны аз жаргал гэж үгүй болой.

7. Үнэхээр бид, салгашгүй харилцан уялдаа шүтэлцээ бүхий хамтын ертөнцөд аж төрдөг гэдгийг хүн төрөлхтөний үйл ажиллагааны үр дагавар, түүний бодит нөлөө яруу тодоор илтгэн харуулсаар байна.

8. Манай гаригийн хувьд оюун ухаант хүн төрөлхтөн бусад биологи дүрсүүдээс давуу шинж үүдийг хүртсэн хэдий ч энэхүү гайхамшигт чөлөө боломжоо хэтрүүлэн ашиглан, амьдралыг тэтгэгч шим мандлын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсаар байна.

9. Амьдралын энэхүү чөлөө нь амьдралыг тэтгэгч агаар, ус, хөрс шороо, бүхий л биологи дүрс хоорондын харилцан уялдаа шүтэлцээ болон тухайн амьдралынх нь үндсэн өгөгдөхүүнт зүй тогтол, мөн чанар, агуулга, хэлбэр, хэв шинжийг ноцтойгоор алдагдуулахгүй байхын төлөө хүлээх тэрхүү үүрэг хариуцлагын хэм хэмжээгээр хязгаарлагдах учиртай.

10. Оюун ухаант хүмүүний амьдрал нь угтаа тэмцэл, сөргөлдөөн, өрсөлдөөн огтхон ч бус бөгөөд тодорхой орон зай, хэм хэмжээ, цаг хугацаанд шүтэлцсэн хамтын ухаалаг бүтээлч үйл ажиллагаа байх учиртай ажгуу.

11. Иймээс оюун ухаант хүмүүний нийгмийн амьдралаа зохион байгуулах агуулга хэлбэр нь тэнгэрлэг сайхан шинж чанарыг агуулах учиртай.

Дэлхий ертөнцийн тухай ухагдахуун

1. Сүнсний сэтгэл оюуныг хөгжүүлэн боловсруулж, төрөл дээшлэх нөхцөл боломж дээд зэргээр бүрдсэн олон гайхамшигт гариг ертөнцийн нэг нь бидний эх дэлхий билээ.

2. Эх дэлхий маань өөрийн гэсэн оюунтай, амьд бие мөн ба үүний нотолгоо нь амьдралыг тэтгэгч шим мандал юм.

3. Манай гариг дээрх хамгийн тансаг зочид буудлыг 5-10 одтой гэж зэрэглэдэг бол хүн төрөлхтний хувьд эх дэлхий нь үлэмж тансаг, үнэмлэхүй гайхамшигтай түмэн одтой үзэсгэлэн төгс зочид буудал гэлтэй.

4. Эх дэлхий бол хүн төрөлхтөний мөнхийн орон гэр огтхон ч бус бөгөөд хүмүүний биеийг олж төрөөд гагцхүү сэтгэл оюунаа хөгжүүлэн, сайжруулж боловсруулах, алдаж үл болох агшин зуурын боломжийг олгож буй боловсрол хүмүүжлийн төв болой.

5. Энэ нь сэтгэл ба оюун бүхий сүнсийг хөгжүүлэн, боловсруулж, төрөл дэвшүүлэх онцгой чухал хувь тавилан, үүрэг хариуцлага манай гариг дээр зөвхөн хүн хэмээх биологийн энэ дүрсэд л оногдсоны учир шалтгаан баталгаа болой.

6. Сэтгэл ба оюуны чадавхийг хөгжүүлж дэвшүүлэх эрхэм хүндтэй үүрэг хариуцлага хүлээсэн оюун ухаант хүмүүнийг таатай сайхнаар оршин амьдарч, цэцэглэн хөгжих ариун үйлсийнх нь тусын тулд л дэлхий дээрх биологийн бүх дүрс оршин тогтнож, үйлчилж байдаг ажгуу.

7. Энэхүү гайхамшигт зохилдолгоо, харилцан шүтэлцээт амьд байгалийн хамтын системээс гадуур, ангид байдлаар оюун ухаант хүн төрөлхтөн амьд байж, оршин тогтнох өчүүхэн ч боломж үгүй билээ.

8. Иймд харьцангуй чөлөөтэй мэт санагдах боловч тус тусын үүрэг хариуцлага, үйл хөдлөлөөр нөхцөлдсөн, нэгдмэл цогц уг системийн ажиллагаанд оюун ухаант хүн нэг бүрийн үйлдэл нь үйлийнхээ цар хүрээнээс хамаарч, их бага ямар нэгэн хэмжээгээр заавал нөлөөлж байх жамтай.

9. Эх дэлхийн биологи дүрс нэг бүр тус тусдаа болон биологийн төрөл зүйлээрээ, өөрийгөө хамгаалах, нөхөн сэргээж төлжүүлэх, бүрэн чадвар бүхий гайхамшигтай боловч энэхүү тэнцвэрээ хадгалан хамгаалах чадвараа алдах гэж бас буй.

10. Энэхүү хязгаарлалтын хүрээг давж гарсан үйл ажиллагааны үр дагавраар, шим мандлын амьдралын хэвийн үйл ажиллагаанд доголдол гарч, үүний уршиг нь

агаар, ус, гол мөрөн, хөрс шороо бохирдлоо өөрөө цэвэрлэж, эрүүлжиж чадахгүй болох биологийн зарим дүрсүүд нэн ховордох, эсхүл хэт олшрох, аль эсвэл бүрмөсөн устаж мөхөх, цаг агаар, уур амьсгалын ноцтой хямрал өөрчлөлт гарч, ган зуд, үер ус, галт уулын дэлбэрэлт, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдлээр байна.

11. Манай гаригийн бүхий л биологи дүрс өөр өөрийн үүрэг зорилтоосоо хамаараад, өөрийн оршин амьдрах цаг хугацаатай. Энэ нь хэдхэн секундээс хэдэн мянган өдрөөр үргэлжлэх бөлгөө.

12. Манай гариг дээр оршин амьдарч буй оюун ухаант хүн нь элдэв золгүй явдлыг эс тооцвол дунджаар 20.000-25.000 –хан хоног л амьдардаг.

13. Энэ хугацаа бол бидний сүнс, хүн хэмээх биологи дүрсэд оршин сууж, зөвхөн сайн үйл бүтээж, оюун санааны төрөл дээшлүүлэх боловсролд зориулагдах учиртай сансрын “нүд ирмэх зуурын” л агшин мөн.

14. Энэ хугацааг оюун ухаант хүн өөрийн дотоод эрчим хүчээр сунгах боломжтой боловч хамгийн чухал нь өгөгдсөн хугацаандаа амжиж, бид оюун санааны зөв сайн төлөвшилтэй болох учиртай.

15. Өөрийн бие цогцсоо эх дэлхий дээр үлдээн одогч сүнс үйлдсэн үйлийнхээ тухай бүхий л мэдээллийг өөртөө агуулан оддог.

16. Дэлхий дээр оршин амьдрагч хүмүүн нь өөрт нь оногдсон сэтгэн бодох, үйл үйлдэх чөлөө боломжийн үүрэг зорилт, мөн чанарыг үл ухаарч, энэхүү боломжоо гагцхүү материаллаг хэрэглээ хангамж төдий явцуу үйл ажиллагаанд зарцуулах нь эцсийн үр дүнд соёл иргэншлийн хөгжил дэвшлийг мухардалд, улмаар сүйрэл мөхөлд хүргэх аюултай.

17. Иймд соёл иргэншил оршин тогтнох хэв маяг болон техник технологийн дэвшил нь бид бүхний амьдралыг тэтгэгч шим мандлын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх “тэр л хүрээ хэмжээгээр” хязгаарлагдаж, харин хүн төрөлхтний оюун санааг сайжруулан боловсруулах үйл явц хэзээ ямагт давамгайлан тэргүүлж байх учиртай.

18. Дэлхийн амьдрал бол зүгээр нэг тохиолдлын хэрэг огтхон ч бус бөгөөд тодорхой зорилго агуулагддаг болох нь бидний санаа бодлоос үл хамааран бодитойгоор оршин буй байгаль дэлхийн болон орчлон ертөнцийн зүй тогтол, тэдгээрийн харилцан шүтэлцээ, уялдаа холбоо, мөн чанараас тодорхой харагдаж байна.

19. Эх дэлхий бол сэтгэл оюунтай амьд махбодь мөн бөгөөд оюун ухаант хүн биднийг тэжээн тэтгэгч ижий, эх дэлхий бол-оюун ухаант хүн төрөлхтөн биднийг сансарын элдэв явдлаас асран хамгаалсан-эцэг, эх дэлхий бол-оюун ухаант хүмүүн бидний оюун санааны төлөвшлөө хөгжүүлэн боловсруулах учиртай эрдэм номын өргөө гэлтэй.

20. Ачлалт эх дэлхий дээрээ муу муухай үйлийг хийх нь бүү хэл хийнэ гэж бодоход ч санаанд үл багтах оюун санааны төлөвшлийг олж авах нэн хариуцлагатай түүхэн цаг үетэй бид золгоод байна.

Үхэл мөхлийн тухай ухагдахуун

1. Үхэл гэдэг нь нэг талаас биологи бие цогцос задран мөхөж, байгаль дэлхийдээ уусан шингэх, нөгөө талаас бие цогцсын хүлээснээс ангижран салж буй сүнс өөрийн үйлийн үрд нөхцөлдөх ертөнцөд шилжихийн өмнөх амьдрал хоорондын завсрын үзэгдэл ажгуу.

2. Үхэл бол амьдралын төгсгөл огтхон ч бус бөгөөд сүнс нэг ертөнцөөс нөгөө ертөнцөд шилжин байршиж амьдрал сэлгэх үйл явц юм.

3. Үхэл нь хэдийгээр ойр дотныхоо хүнээс хагацан салах уй гашууг болдог хэдий ч цаг үргэлж зэрэгцэн оршдогоороо бид бүхэн энэ дэлхийд богинохон хугацаанд тодорхой үүрэг зорилготой ирдгийг байнга сануулагч болой.

Түүхэн зорилт ба Монголын Үндэсний Эв Нэгдлийн Нам

Үнэхээр үзэсгэлэн төгс, үнэнхүү гайхамшигтай зөвхөн хэм хэмжээ, орон зай, цаг хугацааны харилцан шүтэлцсэн зүй тогтолт хатуу хуулинд захирагддаг эх дэлхий дээрээ хүн хэмээх оюун ухаант амьтан өөрийнхөө оюун ухаантай болсны утга учир, үүрэг зорилгыг даанч ухааран ойлгож, танин мэдэж амжаагүйгээс гагцхүү тус тусын хүсэл, сонирхол, шунал тачаалдаа хэт автагдаж, зөвхөн өөрсдийн эрх ашгийн хүрээг өргөтгөх гэж тасралтгүй сөргөлдөн тэмцэлдэж байна.

Хэм хэмжээт сав шим ертөнцөд зохих дэг журмын хүрээнд аж төрөх ёстой байтал хэмжээ хязгааргүй санаан зоргоороо аашилсны үр дагавраар өнөө цагийн дэлхийн байдал улам бүр доройтсоор байгааг бид бүхэн бие сэтгэлээрээ мэдэрч, энэхүү эмх замбараагүй урсгалыг зөнд нь орхиж болохгүй боллоо гэдгийг сэтгэл түгшин ярилцаж, хэрхэн эмх цэгцэнд орж болох гарцыг дор бүрнээ л эрж хайж байгаа боловч, одоо болтол нэгдмэл нэгэн шийдэлд хүрээгүй байсаар байна.

Энэ удаа эв нэгдлийг эрхэмлэгч МҮЭНН хүн төрөлхтөнийг нэгтгэн дагуулж чадах онол хэмээн Мөнх тэнгэрийн хүчний үзэл санааг түмэн олныхоо мэргэн оюунд толилуулж байна. Монголчууд бол эгэл нэгэн улс огтхон ч бус бөгөөд гагцхүү нийт

хүн төрөлхтөний сайн сайхны тусын тулд зүтгэх үүрэг зорилготой, мөнх тэнгэрийн хүчний төлөөлөгчид, оюун санааны язгууртнууд юм.

Монголчууд сэрж, сэтгэж байгаа нь үнэн бол 800 жилийн өмнөх шигээ дэлхийг төвшитгөх оюунлиг үүргийг гүйцэтгэж чадах болно. Өнөөгийн Монголчууд бидний үүрэг бол хүн төрөлхтөний дотоод оюун санааны боловсрол буюу гэгээрэлийн төлөөх хүчин чармайлтад орших болно.

Үүний тулд Монголчууд өөрийн эх орондоо хүн-байгаль зохилдсон хүмүүний тэнгэрлэг сайхан чанарыг хөгжүүлэх оюун санааны боловсролыг дээдэлсэн дэлхийн нийтэд үлгэр дууриалал болох соёл иргэншлийн суурийг тавих учиртай.

Энэ удаагийн дэлхийг төвшитгөх үйл хэргийн гол зэвсэг нь чин ариун, шударга үнэн сэтгэл, зөв үзэл онол, зөв бодлого шийдвэр, зөв зүйтэй хууль журам байх ёстой.

Яагаад гэвэл хүн төрөлхтөнд хэдийгээр яс үндэс, соёл, ёс заншил, шашин шүтлэг болон бусад ялгарах олон зүйл байгаа боловч хүн бүхэн хайр энэрэл, сайн сайхан, аз жаргалыг хүсэж тэмүүлдгээрээ нэгэн адил тул жинхэнэ зөв шударгыг, зөвшөөрөх нь гарцаагүй.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө хүчин зүтгэх хувь тавилан, түүхэн үүрэг хариуцлага Монголын Үндэсний Эв Нэгдлийн Намд оногджээ. Мөнх тэнгэрийн хүчний үзэл санаагар Монголчууд бид хүн төрөлхтөнийг төвшитгөн нэгтгэх маш хүнд хэцүү боловч, гайхамшигт үйлсийнхээ гарааг эхэлж байгааг Монголын Үндэсний Эв Нэгдлийн Нам нэн хүндэтгэлтэйгээр зарлан тунхаглаж байна.

Зүрх сэтгэлээ нээж, зөн билгээ шинжиж, хамгийг хайрлан энэрч, ойлгон хүндэтгэх халуун дулаан нэгэн үзүүрт сэтгэлээр мөнх тэнгэрийн хүчин дор нэгдэгтүн!